



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 23 өдөр

Дугаар A/210

Мөрөн сүм

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолоор баталсан “Газар өмчлүүлэх эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн A/172 дугаар захирамжийн дагуу 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдөр явагдах газар эзэмшүүлэх цахим дуудлага худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

3. Нямбаяр (Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын удирдлагын хэлтсийн дарга)

Гишүүд:

Ө. Дугарсүрэн (Аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын мэдээлэлийн сан, техник, программ хангамж хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Б. Батмөрөн (Аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын газрын татвар, төлбөр үнэлгээ хариуцсан мэргэжилтэн)

2. Газар эзэмшүүлэх цахим дуудлага худалдааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (3. Нямбаяр) -д даалгасугай.

3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б. Ганзориг)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ш. ИДЭРБАЯСГАЛАН